

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛС
БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙН ТӨСЛИЙГ
ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 03 дугаар
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдөр “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир энэ төрлийн хэлэлцээрийг өөр улс оронтой байгуулсан эсэх, өнгөрсөн хугацаанд энэ төрлийн хэлэлцээрийг хэрхэн ашигласан, ямар үр дүнд хүрсэн, энэ төрлийн хэлэлцээрийн дагуу авлигатай тэмцэх болон Засгийн газраас хэрэгжүүлж буй “5 Ш” ажиллагаатай холбоотойгоор тодорхой үйл ажиллагаа явуулсан эсэх, тодорхой этгээдийг шилжүүлэх, авчрах, хоёр улсын хооронд ялтан шилжүүлэх ажиллагаа хийгдсэн эсэх, Бүгд Найрамдах Чех Улсад гэмт хэргийн улмаас хохирсон Монгол Улсын иргэн байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал хэлэлцээрийн төслийн Хавсралт дахь нууцын зэрэглэл тогтоосон заалттай холбогдуулан Чехийн талаас шилжүүлэн өгсөн хязгаарлагдмал мэдээллийг Монголын тал нууцын зэрэглэлд авч үзэхээр заасан нь оновчтой эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг уг хэлэлцээрийг байгуулснаар Европын улс орнуудад Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, Европын улс орны туршлагаас суралцах эхлэл болох тул уг төслийг дэмжиж байгаа талаар; Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин манай улс хүний эрхийн мэдрэмжтэй, хуулийн засаглалд ойлтсон барууны орнуудтай хамтын хэлэлцээрийг соёрхон баталснаар цагдаагийн байгууллага, хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий холбогдох байгууллагууд соёл солилцох, арга барилд суралцах, хүний эрхийн мэдрэмжтэй ажиллахад чухал үр нөлөөтэй учраас уг төслийг дэмжиж байгаа бөгөөд мөрдөн шалгах ажиллагааны нууцтай холбоотой Эрүүгийн хуулийн холбогдох зохицуулалтыг сайжруулах шаардлага байгаа тул уг нэмэлт, өөрчлөлтийг хийхдээ хэлэлцээрийн төслийн холбогдох зохицуулалттай нийцүүлэхэд анхаарах талаар; Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд хэлэлцээрийн төслийн орчуулга нь оновчтой эсэх, монгол орчуулгын үг хэллэг эрх зүйн түгээмэл нэр томъёонд хэрэглэгддэггүй хэллэг ашигласан, нэг заалтад хоёрдмол утга илэрхийлсэн, хэл зүй, найруулгын хувьд

засаж сайжруулах шаардлага байгаа тул төслийн англи болон монгол хэл дээрх эхийн орчуулгыг нягтлах нь зүйтэй, түүнчлэн зарим төрлийн хэрэг зөрчлийг Европын 27 улсын стандартад нийцүүлэх талаар ямар зохицуулалт хийхийг анхаарах нь зүйтэй талаар; Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хэлэлцээрийн дагуу мэргэжилтнүүд бэлтгэх, боловсон хүчнийг солилцох, шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчдыг бэлтгэх зэрэг асуудлаар Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам төлөвлөгөө гаргах, төсвийг хуваарилах, бодит ажил болгох тал дээр онцгой анхаарах, түүнчлэн тодорхой гэмт хэргүүдийг нэрлэн заасныг анхаарч цахим гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд Европын холбооны улсуудын туршлагаас суралцахад анхаарах нь зүйтэй талаар тус тус санал хэлсэн болно.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 75 хувь нь зөвшилцөхийг дэмжиж, санал дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



П.САЙНЗОРИГ